



Монгол Улсын Их Сургуулийн Байгаль-Эх лицей ахлах сургуулийн  
гүнзгийрүүлсэн сургалттай ангид суралцуулах ГЭРЭЭ

2015 оны 10 дугаар сарын 19

№ 15/024

Улаанбаатар хот

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Суралцах гэрээг нэг талаас МУИС-ийн Байгаль-Эх лицей ахлах сургуулийг төлөөлж сургалтын менежер Төвдөө овогтой Буяндэлгэр, нөгөө талаас ..... 10 ..... ангийн ..... Сандагурийн ..... овогтой ..... Сандагурийн ..... /цаашид суралцагч гэх/, эцэг /эх/ ..... Бүрэг ..... овогтой ..... албаны ..... нар харилцан тохиролцож Монгол Улсын Боловсролын багц хууль, Байгаль-Эх лицей ахлах сургууль, Экологийн боловсролын төвийн дүрмийг үндэслэн байгуулав.

1.2. Сургууль, суралцагч, эцэг /эх/-ийн харилцааг Боловсролын тухай багц хууль, бусад хууль тогтоомж, Байгаль-Эх лицейд мөрдөгдөж буй дүрэм, энэхүү гэрээгээр зохицуулж тэдгээрт заагдсан үүргийг талууд адил хүлээнэ.

1.3. Суралцагч нь суралцах хугацааны хичээлийн жил тутамд сургалтын нэмэгдэл зардал болох төлбөрийг /Удирдах зөвлөл тогтоосон/ төлнө.

**Хоёр. Сургуулийн хүлээх үүрэг**

2.1. Суралцагч бүрт чанартай, хүртээмжтэй бүрэн дунд боловсрол олгох, хүүхэд бүрийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх, хүсэл сонирхол, онцлогт нийцсэн боловсролын үйлчилгээ үзүүлэхийг эрхэмлэн бүхий л нөөц боломж, чадавхийг дайчлан ажиллана.

2.2. Суралцагчиддаа сургалт явуулахад зайлшгүй шаардагдах сургуулийн эзэмшлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хичээлийн лаборатори, биеийн тамирын заал, номын сангийн үйлчилгээг үнэ төлбөргүй ашиглаулна.

2.3. Суралцагчид бүрэн дунд боловсролын стандартыг бүрэн эзэмшуулэхийн зэрэгцээ, сонгосон хичээлийг гүнзгийрүүлэн зааж, амжилттай суралцаж төгссөн бол бүрэн дунд боловсролын үнэмлэх олгоно.

2.4. Гүнзгийрүүлэн судалсан хичээлүүдийн түвшин тогтоо шалгалт болон бусад хичээлүүдээр улирал тутам хангалтгүй үнэлэгдсэн, суралцах үүргээ хангалтгүй биелүүлсэн, өөрийгөө дайчлахгүй байгаа суралцагчийн гэрээг дараах шаталтайгаар дүгнэнэ.

- 1-р улиралд анги удирдсан багш суралцагчийн гэрээний явцыг дүгнэж суралцагч, эцэг эх, асран хамгаалагчид танилцуулж, арга зүйн зөвлөгөөг өгнө.
- 2-р улиралд анги удирдсан багш хангалтгүй үнэлгээтэй суралцагч болон эцэг эхэд мэдэгдэх хуудсыг хүргүүлнэ.
- 3-р улиралд гэрээг Захирлын дэргэдэх зөвлөлийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэж, гүнзгийрүүлэн судалсан хичээлийн түвшин тогтоо шалгалт болон улирлын дүнгээр гурав ба түүнээс дээш хичээлд хангалтгүй (F) үнэлгээтэй суралцагчид сануулга өгнө.
- 4-р урилалд сануулга авсан суралцагчийн хангалтгүй үнэлгээтэй хичээлийн тоонд өөрчлөлт ороогүй тохиолдолд багш нарын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, цуцлах хүртэл арга хэмжээг авна.

**Гурав. Сургуулийн эдлэх эрх**

- 3.1. Суралцагчаас гэрээгээр хүлээсэн үүргээ ямагт биелүүлэхийг шаардах.
- 3.2. Холбогдох дүрэм, журамд заасны дагуу суралцах гэрээг цуцлах.

**Дөрөв. Суралцагчийн эрх**

- 4.1. Суралцах нөхцөл бололцогоор хангуулах.
- 4.2. Сургуулийн үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлтээ гаргах.

### **Тав. Суралцагчийн хүлээх үүрэг**

- 5.1. Сургалтын хөтөлбөрийн агуулгыг хугацаанд нь бүрэн эзэмших, амжилттай /стандарт үнэлгээ 80%-аас доошгүй/ суралцахын төлөө өөрийн бүхий л нөөц боломжоо бүрэн дайчлан ажиллах.
- 5.2. Суралцагчийн ёс зүйн дүрмийг зөрчихгүй байх, сургууль багшаас тавьсан шаардлага, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, сургуулийн дотоод журам, бусад мөрдөгдөж буй дүрмийг хүндэтгэн сахих.
- 5.3. Сургалтын нэмэгдэл зардал болох төлбөрийг зохих хугацаанд бүрэн төлөх.
- 5.4. Сургууль хамт олноос зохион явуулсан урапдаан тэмцээн, олимпиадад идэвхтэй оролцож байх.
- 5.5. Сургуулийн удирдах ажилтан, анги удирдсан болон хичээл заадаг багш нар, суралцагчдын өөрөө удирдах зөвлөл /СӨҮЗ/, анги хамт олноос өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд чанартай гүйцэтгэж байх.

### **Зургаа. Эцэг /эх/-мийн эдлэх эрх**

- 6.1. Суралцагчийн мэдлэг, чадварын талаарх мэдээллийг цаг тухайд нь авах.
- 6.2. Сургуулийн үйл ажиллагаа, багш наортай холбоотой асуудлаар санал хүсэлт гаргах.

### **Долоо. Эцэг /эх/-ийн хүлээх үүрэг**

- 7.1. Хүүхдээ “Зөв Монгол Хүн” болон төлөвших, амжилттай сайн суралцаж авьяас чадвараа нээн хөгжүүлэхэд нь гэр булийн хүрээний шаардлагатай нөхцөл боломжоор хангах.
- 7.2. Сургууль, багш наортай байнгын холбоо харилцаатай байж хамтран ажиллах.
- 7.3. Улирал тутмын болон явцын түвшин тогтох шалгалтын дүн, хүүхдийнхээ мэдлэг чадварын өсөлт, ахиц өөрчлөлтийг анхаарч гурвалсан гэрээний биелэлтийг дэмжиж байх.
- 7.4. Ангийн болон сургуулийн эцэг /эх/-ийн зөвлөл, анги удирдсан багш, сургуулиас зохиосон сургалт-төлөвшлийн аливаа ажилд идэвхтэй бүтээлч оролцох, бүх талаар дэмжиж ажиллах.

### **Найм. Гэрээ цуцлах нөхцөл**

Дараах тохиолдолд энэхүү гэрээг сургуулийн санаачлагаар цуцална. Үүнд:

- 8.1. Бусдыг хэл амаар доромжлох, нэр хоч өгөх, бүлэглэн дарамтлах, сэтгэл санааны болон бие махбодын хохирол учруулах, хулгай хийх, мөнгө төгрөг нэхэх зэрэг хэв журмын зөрчил гаргасан.
- 8.2. Гүнзгийрүүлэн судалсан хичээлийн түвшин тогтоо шалгалт болон улирлын дүнгээр гурав ба түүнээс дээш хичээлд хангалтгүй (F) үнэлэгдсэн.
- 8.3. Согтууруулах ундаа, архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэсэн, элдэв муу зуршилд автах болон хэв журмын ноцтой зөрчил гаргасан.

### **Ес. Гэрээний хүчинтэй хугацаа, маргаан шийдвэрлэх**

- 9.1. Энэхүү гэрээг 3 талын гарын үсэг зурсан өдрөөс хүчинтэйд тооцно.
- 9.2. Гэрээг гурван жилийн хугацаагаар байгуулна.
- 9.3. Гэрээний 8.1, 8.3 дахь хэсгээр гэрээ цуцлагдсан тохиолдолд сургалтын төлбөрийн үлдэгдлийг буцааж олгохгүй, харин суралцагчийн санаачлагаар гэрээ цуцлагдвал сургалтын үлдэгдэл төлбөрийн 10% нь сургуульд үлдэж, үлдсэн хувийг сурагцагчид олгоно.
- 9.4. Гэрээ цуцлах асуудлаар маргаан үүсвэл аль ч тал боловсролын мэргэжлийн хяналтын байгууллагад хандах эрхтэй.

**Гэрээ байгуулсан:**

Байгаль-Эх лицей ахлах  
сургуулийн сургалтын менежер

  
T. Буянзэлгэр

Утас: 88001664

10<sup>т</sup>  
.....  
ангийн сурагч

  
C. Санчир  
Санчир

Утас: 94973199

Эцэг /эх/

  
B. Санжаасүрэн  
Санжаасүрэн

Утас: 93213259  
93213255

